



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/39

Шивээговь сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
 шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулахтай холбогдуулан сумын хэмжээнд 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 07:00 цагаас 19:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд өгөгдсөн цагийн байдалд үнэлгээ хийн, арга хэмжээг төлөвлөн, сургуулийг чанартай зохион байгуулж ажиллахыг сумын Онцгой комиссын гишүүд, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн дарга (Ц.Цэрэндорж)-д үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж оролцохыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг уриалсугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг сумын Засаг даргын орлогч бөгөөд Онцгой комиссын орлогч дарга (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ